



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/02/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Х.Билэгбаяр Утас: 94009818 Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018501, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2021.12.15 № 158

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБЯАР

07020417

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>210,463,726.95</u>	<u>188,154,726.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	25,088,675.15	682,725.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	25,088,675.15	682,725.04
3121	Төгрөг	25,088,675.15	682,725.04
31211	Төрийн сангийн харилцах	25,088,675.15	682,725.04
33	АВЛАГА	3,016,900.00	2,530,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,530,000.00	2,530,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	182,358,151.80	184,942,001.80
354	Хангамжийн материал	182,358,151.80	184,942,001.80
35410	Бичиг хэргийн материал	613,625.00	1,071,720.00
35420	Аж ахуйн материал	3,041,758.40	4,412,058.40
35430	Сэлбэг хэрэгсэл	172,045,670.00	169,051,625.00
35440	Түлш, шатах тослох материал	763,150.00	3,850,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,893,948.40	6,556,598.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,658,347,434.33</u>	<u>10,511,039,675.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,658,347,434.33	10,511,039,675.89
392	Биет хөрөнгө	751,147,434.33	603,839,675.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	218,395,446.00	218,395,446.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,575,865.08)	(24,715,426.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,136,934.20	50,136,934.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,551,501.27)	(25,645,194.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,394,470,930.13	3,426,924,404.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,876,086,432.27)	(3,047,068,255.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,755,337.20	19,549,632.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,397,414.58)	(13,737,864.23)
393	Биет бус хөрөнгө	9,907,200,000.00	9,907,200,000.00
39301	Програм хангамж	2,270,000.00	2,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,270,000.00)	(2,270,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,907,200,000.00	9,907,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10,868,811,161.28</u>	<u>10,699,194,402.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>230,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	230,000.00
413	Өглөг	-	230,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	230,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10,868,811,161.28</u>	<u>10,698,964,402.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,868,811,161.28	10,698,964,402.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		11,247,971,155.00	11,247,971,155.00
51101	Өмч: - төрийн	11,247,971,155.00	11,247,971,155.00
512	Хуримтлагдсан үр дүн	(875,947,925.54)	(1,045,513,509.09)
51210	Өмнөх үеийн үр дүн	(875,947,925.54)	(875,666,750.54)

51220	Тайлант үеийн үр дүн	-	(169,846,758.55)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	496,787,931.82	496,506,756.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,868,811,161.28	10,699,194,402.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	295,686,353.00	298,912,316.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,186,004.00	29,738,478.59
120	Нийтлэг татварын бус орлого	5,186,004.00	29,738,478.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,651,404.00	29,738,478.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,651,404.00	2,956,208.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	26,782,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	290,500,349.00	269,173,838.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	290,500,349.00	269,173,838.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,245,440.00	269,173,838.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	432,783,255.36	468,759,075.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	432,783,255.36	468,759,075.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	431,513,255.36	454,712,687.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,381,929.00	150,817,343.00
210101	Үндсэн цалин	112,860,104.00	118,735,953.00
210102	Нэмэгдэл	20,676,871.00	9,825,867.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,341,500.00	9,782,500.00
210104	Урамшуулал	15,503,454.00	12,473,023.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,965,938.13	19,502,372.32
210201	Тэтгэврийн даатгал	13,380,255.29	13,595,317.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,455,547.53	1,422,314.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,238,981.50	1,181,749.64
210204	Ажилгүйдлийн даатгал	519,364.16	289,338.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,371,789.65	3,013,651.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,707,456.38	23,904,673.38
210301	Гэрэл, цахилгаан	16,369,653.38	14,712,818.38
210302	Түлш, халаалт	7,646,750.00	7,537,150.00
210303	Цэвэр, бохир ус	1,691,053.00	1,654,705.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,845,366.18	10,440,920.00
210401	Бичиг хэрэг	812,665.00	998,105.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	4,525,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	411,741.18	323,180.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,056,660.00	1,396,010.00
210408	Бараа материал ахисны зардал	00.00	3,198,625.00
2105	Нормативт зардал	2,169,520.00	6,294,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,169,520.00	6,294,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,600,992.00	23,663,800.00
210604	Урсгал засвар	6,600,992.00	23,663,800.00

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	760,000.00	1,908,800.00
210702	Дотоод албан томилолт	760,000.00	1,908,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,911,544.98	23,745,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,062,924.98	5,002,130.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,663,120.00	12,663,120.00
210807	Газрын төлбөр	6,185,500.00	6,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,170,508.69	194,434,928.44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	189,170,508.69	194,434,928.44
212	ТАТААС	00.00	895,420.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	895,420.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	895,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,000.00	13,150,968.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,000.00	13,150,968.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,000.00	13,150,968.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-137,096,902.36	-169,846,758.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-137,096,902.36	-169,846,758.55

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,247,971,155.00	496,787,931.82	-875,947,925.54	10,868,811,161.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	281,175.00	281,175.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,247,971,155.00	496,787,931.82	-875,666,750.54	10,869,092,336.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-281,175.00	00.00	-281,175.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-169,846,758.55	-169,846,758.55
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,247,971,155.00	496,506,756.82	1,045,513,509.09	10,698,964,402.73

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	257,863,844.00	272,130,046.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,618,404.00	2,956,208.59
120	Нийтлэг татварын бус орлого	7,618,404.00	2,956,208.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,083,804.00	2,956,208.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,083,804.00	2,956,208.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,245,440.00	269,173,838.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,245,440.00	269,173,838.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,245,440.00	269,173,838.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	241,803,315.67	276,191,096.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,803,315.67	276,191,096.70

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,533,315.67	263,270,128.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,166,765.00	150,330,443.00
210101	Үндсэн цалин	158,166,765.00	150,330,443.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,965,938.13	19,502,372.32
210201	Тэтгэврийн даатгал	13,380,255.29	13,595,317.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,455,547.53	1,422,314.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,238,981.50	1,181,749.64
210204	Ажилгүйдлийн даатгал	519,364.16	289,338.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,371,789.65	3,013,651.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,247,706.38	26,891,523.38
210301	Гэрэл, цахилгаан	16,369,653.38	14,712,818.38
210302	Түлш, халаалт	5,187,000.00	10,524,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,691,053.00	1,654,705.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,062,441.18	8,235,380.00
210401	Бичиг хэрэг	763,900.00	1,456,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	4,625,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	411,741.18	323,180.00
210404	Ном, хэвлэл	00.00	45,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	940,500.00	1,786,000.00
2105	Нормативт зардал	1,714,420.00	7,109,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,714,420.00	7,109,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,704,500.00	24,432,600.00
210604	Урсгал засвар	7,704,500.00	24,432,600.00
2107	Томилолт, зочны зардал	760,000.00	1,908,800.00
210702	Дотоод албан томилолт	760,000.00	1,908,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,911,544.98	24,859,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,062,924.98	6,116,830.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,663,120.00	12,663,120.00
210807	Газрын төлбөр	6,185,500.00	6,080,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,000.00	12,920,968.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,000.00	12,920,968.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,000.00	12,920,968.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,060,528.33	-4,061,050.11
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,459,000.00	20,344,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,459,000.00	20,344,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,459,000.00	20,344,900.00
222001	Тонг төхөөрөмж	00.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,459,000.00	20,344,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,459,000.00	-20,344,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14,601,528.33	-24,405,950.11

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,487,146.82	25,088,675.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,088,675.15	682,725.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	279,473,838.00	278,835,996.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	279,473,838.00	278,835,996.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,542,870.00	265,915,028.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,466,320.00	150,330,443.00
210101	Үндсэн цалин	150,466,320.00	150,330,443.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,595,460.00	19,502,372.32
210201	Тэтгэврийн даатгал	13,576,796.00	13,595,317.76
210202	Тэтгэмжийн даатгал	1,504,664.00	1,422,314.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,203,732.00	1,181,749.64
210204	Ажилгүйдлийн даатгал	300,940.00	289,338.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,009,328.00	3,013,651.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,936,390.00	26,891,523.38
210301	Гэрэл, цахилгаан	14,722,790.00	14,712,818.38
210302	Түлш, халаалт	10,557,000.00	10,524,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,656,600.00	1,654,705.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,367,740.00	8,235,380.00
210401	Бичиг хэрэг	1,470,100.00	1,456,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,681,290.00	4,625,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	350,000.00	323,180.00
210404	Ном, хэвлэл	66,350.00	45,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,800,000.00	1,786,000.00
2105	Нормативт зардал	7,123,240.00	7,109,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,123,240.00	7,109,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,018,400.00	26,917,500.00
210604	Урсгал засвар	27,018,400.00	26,917,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,918,530.00	1,908,800.00
210702	Дотоод албан томилолт	1,918,530.00	1,908,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,116,790.00	25,019,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,287,670.00	6,276,830.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,729,120.00	12,663,120.00
210807	Газрын төлбөр	6,100,000.00	6,080,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,930,968.00	12,920,968.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	12,930,968.00	12,920,968.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,930,968.00	12,920,968.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,700,000.00	17,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,700,000.00	17,700,000.00
222001	Тоног төхөөрөмж	17,700,000.00	17,700,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	297,173,838.00	272,130,046.59
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	294,173,838.00	269,173,838.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	294,173,838.00	269,173,838.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000.00	2,956,208.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	2,956,208.59
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,487,146.82	25,088,675.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,088,675.15	682,725.04

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газар нь “Баруун бүс нутаг дэвсгэрт радио телевизийн өргөн нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд дамжуулан хүргэх сүлжээний техникийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангаж шинэ техник технологийг нэвтрүүлэн ард түмэнд мэдээллээр үйлчилдэг” байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зарлага 278.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 469.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.4 сая төгрөг, 80 хувь буюу 7.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 169.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 3.0 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлагыг бууруулсантай холбоотой байна. Үлдэгдэл 2.5 сая төгрөгийн авлагыг шүүх хуулийн байгууллагад хандаж барагдуулах талаар ажиллаж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 184.8 сая төгрөг болж 2.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 51.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 48.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,624.5 сая төгрөг болж 35.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 20.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 26.8 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 11.9 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,699.0 сая төгрөг болж 169.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 169.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 297.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 297.2 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвөөс санхүүжүүлэхээр 297.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр 297.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 296.5 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 296.5 сая төгрөг буюу 99 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Авто машины сэлбэг засвар үйлчилгээ, шатахууны зарцуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулан хяналт тавьж ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний дагуу суутгалыг тухайн иргэнээс хийх шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг

санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говь-Алтай аймгийн Радио телевизийн сүлжээний газар нь 2021 онд нийт 296.5 сая төгрөгийн 150 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 296.5 сая төгрөгийн 150 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 44.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах 3 заалттай 2.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар: Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 38.4 сая төгрөгийг залруулан, 48.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 32.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, И баримтгүй 6.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэнд нөхөн шивүүлэн тус тус залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 44.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 0.7 сая төгрөгийг баяр ёслол тэмдэглэлт арга хэмжээнд зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Сэлбэг, хэрэгслийн эдэлгээний доод хязгаарыг баримтлалгүйгээр 1.4 сая төгрөгийн сэлбэг авч авто машинуудад засвар үйлчилгээ хийсэн бөгөөд хувийн хэрэгт бичилт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Татварын тодорхойлолтоор 1.3 сая төгрөгийн 3 нэр төрлийн татварын өглөг, авлагын тооцоог нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Радио телевизийн сүлжээний газар	5.0	41.7	1	38.4	0.0	0.0	4	3.3	0.0	0.0
Дүн											
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Радио телевизийн сүлжээний газар	1.0	44.7			0.0	0.0	1	44.7	0.0	0.0
Дүн											
Нийт дүн		6.0	86.4	1	38.4	0	0	5	48.0	0.0	0.0